

Удирдагч ба бичиг хэргийн ажилтны мэдээллийн санг (УБХАМС) хэрхэн эхлүүлэх талаарх товч

удирдамж

2014 оны 12-р сарын 1

УБХАМС нь ГУУ-г орлох, онлайн бүртгэл хөтлөх хэрэгсэл юм. УБХАМС-г ашиглах давуу тал нь

- Удирдагч, бичиг хэргийн ажилтан болон тойргийн зөвлөлийн гишүүд гэртээ, гар утас ашиглаж гэх мэт интернэтэд холбогдох ямар ч газар бүртгэл хөтлөх үүрэгт ажлаа биелүүлэх боломжтой.
- Бодит хугацаанд мэдээллийг боловсруулна. Энэ нь ГУУ дэх гишүүнчлэлийн бүртгэлд шинэчлэлтүүд шууд орно гэсэн үг.
- Сахилгын хурлын баримт зэрэг баримт бичгийг Сүмийн удирдах газар руу онлайнаар оруулах боломжтой болсоноор цаасан баримтыг хэвлэх, э-мэйлээр явуулах шаардлаггүй..

УБХАМС руу нэвтрэн орж, ашиглаж эхлэхийн тулд доорх алхмуудыг дагана уу.

1 ХҮГ данс үүсгэ

Хэрэв танд ХҮГ данс байхгүй бол ldsaccount.lds.org руу орж, **Register for an LDS Account** товч дээр дарна уу. Танд таны гишүүнчлэлийн бүртгэлийн дугаар (ГБД) хэрэг болох ба та түүнийг тойргийнхоо бичиг хэргийн ажилтнаас авах боломжтой. ХҮГ данс үүсгэснийхээ дараа та УБХАМС руу нэвтрэх хэрэглэгчийн нэр болон нууц үгтэй болно.




2 Дуудлагаа магадлан шалгах

Зөвхөн тодорхой дуудлага бүхий хүмүүс УБХАМС рүү нэвтрэн орох боломжтой. Үүнд, гадасны ерөнхийлөгчийн болон бишопын зөвлөлүүд, гадас болон тойргийн бичиг хэргийн ажилтнууд болон гүйцэтгэх нарийн бичгүүд, мөн тойргийн зөвлөлийн гишүүд болон тэдгээрийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд орно.


3 УБХАМС руу нэвтрэн орж, үйлдлүүдтэй танилц

Интернетийн хайлтын цонхонд lds.org/lcr гэж оруулаад Enter товч дээр дарна уу. УБХАМС-ийн үндсэн дэлгэц рүү орохын тулд та ХҮГ дансныхаа хэрэглэгчийн нэр болон нууц үгийг ашиглан нэвтрэж орно. УБХАМС-ийн цэсний гарчигууд дээр дарж боломжит үйлдлүүдтэй танилцана уу.



4 Тусламж

Тусламж цэс дээр дарж сонголтын жагсаалтыг үзнэ үү. Тусламжийн төвийн вэбсайт руу орохын тулд та Ерөнхий тусламж дээр дарах ба тэндээс туслах заалтыг сэдвээр нь хайх боломжтой. Гадасны ерөнхийлөгчийн болон бишопын зөвлөлүүд, мөн бичиг хэргийн ажилтнууд Бидэнтэй холбоо барина уу товч дээр дарснаар Глобал үйлчлэлийн төв (ГҮТ) эсвэл орон нутгийнхаа удирдах албатай холбоо барих мэдээллийг олж харж болно.



5 Эвдрэл гэмтлийг илрүүлж арилгах

Хэрэв УБХАМС рүү нэвтэрч орох эсвэл ашиглахад асуудал гарвал та дараах арга хэмжээг авна уу:

- Интернэтийн холболт найдвартай эсэхийг шалга.
- ХҮГ дансыг нээхэд өөрийн гишүүнчлэлийн бүртгэлийн дугаарыг ашигласан эсэхийг шалга.
- Таны Сүмийн дуудлагыг жишиг албан тушаалуудыг ашиглан зөв бүртгэсэн эсэхийг тойргийнхоо бичиг хэргийн ажилтнаас асууж лавлах.
- Таны интернэт браузер сүүлийн үеийн хувилбараар шинэчлэгдсэн эсэхийг шалга. Хэрэв та Internet Explorer (IE) ашиглаж байгаа бол УБХАМС-ийн үйл ажиллагаа хэвийн явагдахад 10 болон түүнээс дээш хувилбартай байх шаардлагатай. IE –ыг хэрхэн шинэчлэх талаар олж мэдэхийг хүсвэл <http://windows.microsoft.com/ie> руу орно уу. **Windows XP эсвэл үүнээс өмнөх хувилбарын програм ашиглаж байгаа компьютерууд IE-ыг сүүлийн үеийн хувилбар руу ахиулах боломжгүй ба УХАМС-д нэвтрэхийн тулд Google Chrome-ыг ашиглах хэрэгтэй.** Chrome-ыг татаж авахын тулд <http://www.google.com/chrome> руу орно уу.
- Хэрэв танд УБХАМС-ийн үндсэн дэлгэц дээрх зургаан цэс дээр үзүүлсний адил харагдахгүй байвал Удирдагч ба бичиг хэргийн ажилтны мэдээллийн сан гарчигийн хажууд байрлах цэсийн товчлуур дээр дарж харна уу. УБХАМС-ийн дэлгэц автомат тохиргоотой тул бүх төрлийн зөөврийн төхөөрөмж ашиглаж байгаа хүмүүст хэрэглээг илүү хялбар болгож өгнө.

